

МИСС ТЭМДЭГЛЭЛ

MICC.mn

2012 ОНЫ 5 ДУГААР САРЫН 10 (12)

14 хоног тутам гарна

MONGOLIA INTERNATIONAL CAPITAL CORPORATION — Монголын тэргүүлэх хөрөнгө оруулалтын банк

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭ

- Стратегийн салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэж байна. Хуулийн төсөл нь эрдэс баялгийн салбарыг хамрах бөгөөд одоогийн хувилбараар гадаадын хөрөнгө оруулалтыг 49 хувьд хязгаарлана.
- Авилгалтай тэмцэх газар **SouthGobi Resources** компанид шалгалт хийжээ.
- **Таван Толгойн IPO** 2013 он хүртэл хойшлогдох байх гэж Эрдэнэс ТТ компанийн захирал Энэбиш мэдэгджээ.
- **Ivanhoe Mines** компанийн шинэ гүйцэтгэх захирлаар **Kay Priestley** хэмээх өмнө нь “**Rio Tinto Зэс**”-ийн санхүүгийн захирал байсан эмэгтэй томилогдлоо.
- **Оюу Толгой, Entree Gold** компаниудын эзэмшил “Хэруга” орд дээрх хайгуул зэс, молибден нэмж олсоор байна.
- **Хөгжлийн Банк АНУ**-тай хийх худалдааг нэмэгдүүлэх зорилгоор тус улсын Экспорт-Импорт Банктай санамж бичиг байгууллаа.
- **Aspire Mining** нэгдүгээр улирлын тайлгаа гаргалаа. Овоот ордын өрөмдлөгийн мэдээ, төмөр замын урьдчилсан ТЭЗҮ гарчээ.
- **Voyager Resources** нэгдүгээр улирлын тайлангаа гаргалаа. Аранжингийн өрөмдлөгийн зарим мэдээ гарчээ.
- Швецарийн **SGS SA Оюу Толгойн** талбайн лабораторийг барих гэрээ байгууллаа.
- Чулуун Хороо уурхайг эзэмшдэг **Eumeralla Resources** Австралийн бирж дээр IPO хийжээ.
- **Kincora Copper** Хүрэл Үнэг ордын ойр хавьд хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг **Golden Grouse**-ийг худалдаж авлаа.
- **Draig Resources**-ийн Тээгийн орд дахь нэг өрөмдлөгөөс 86 метрийн нүүрс олджээ.

Монгол улсын эрдэс баялгийн бодлого



Б. Ачболд


СОНГУУЛЬ ОЙРТОХЫН хэрээр улс төр хөдөлгөөнд ордог. Энэ удаа эдийн засаг, зах зээлд нөлөөлөх хэд хэдэн үйл явдлууд болж байгаа нь бидний анхаарлыг татлаа.

Хятадын төрийн эзэмшлийн компанид худалдагдана гэсэн **SouthGobi Resources** компанийг тойрсон асуудлууд олны анхаарлын төвд байсаар байна. Харин энэ компанийн үйл ажиллагаанаас илүү Монголын төр энэ асуудалд яаж хандах нь Монголчуудын хувьд ч, хөрөнгө оруулагчдын хувьд ч илүү ач холбогдолтой юм.

Монгол улсын эрдэс баялгийн бодлогын том хэсгийг бүрдүүлэх хуулийг Улсын Их Хурал өнөөдөр хэлэлцэж байна. Гадаад харилцааны сайд Г. Занданшатарын хэлснээр “стратегийн” ач холбогдолтой салбар, аж ахуй нэгжүүдийг санхүүжүүлэх гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах энэхүү хуулийг 2009 оноос хойш боловсруулсаар иржээ. Харин **SouthGobi**-гийн шуугиан гарснаас хойш хуулийг хурдан батлах шаардлага гарсан байна. Хуулийн анхны хувилбарт Засгийн газар, УИХ-ын ажлын хэсгээс хэд хэдэн засвар санал болгосныг хуулийн шинэ хувилбарт тусгажээ. Энэ хоёрдох хувилбар нь интернэт дээр цацагдаж, **Financial Times** мэтийн томоохон хэвлэлүүдийн анхаарлыг татаж, хөрөнгө оруулагчдыг багагүй сандаргав. Учир нь “стратегийн” салбарын тодорхойлолт нь нилээд өргөн утгатай байсны дээр тус хууль нь эдгээр салбаруудад гадны хөрөнгө оруулалтыг



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДРУУЛГА



49 хувиар хязгаарлах юм. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нэмж хэлэлцсэний үндсэн дээр стратегийн салбарын тодорхойлолтыг өөрчилж үүнд дөрвөн салбарыг оруулсан: эрдэс баялаг, банк санхүү, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо. Мөн 100 тэрбум төгрөгөөс өндөр үнэлгээтэй аж ахуй нэгжийг стратегийн ач холбогдолтой гэж үзэхээ болив. Энэхүү тодорхойлолтоор бол уул уурхайн бүх компаниуд хуульд хамрагдах бөгөөд гадны эзэмшил 49 хувиас хэтрэхгүй юм байна. Ийнхүү хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр болж тогтов.

Хуулийн төсөл батлагдсан батлагдаагүй УИХ-ын гишүүд гадаадын хөрөнгө оруулалт дээр илүү хатуу бодлого баримтлах болжээ. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль бол үүний нэг жишээ юм. Бас нэг жишээ бол Ашигт Малтмалын Газрын шинэ даргаар геологич, уурхайн инженер, эдийн засагчийг биш харин Тагнуулын Ерөнхий Газрын орлогч дарга Г. Алтансүхийг томилсон байна. “Үндэсний аюулгүй байдал юунаас ч чухал байгаа энэ цаг үед... Алтансүх яг тохирох хүн” гэж Засгийн газрын тэргүүн хэлжээ.

Төрийн бодлого яагаад өөрчлөгдөж байгааг хүн болгон гадарлаж байгаа байх. Сонгууль ойртохын хэрээр гишүүд ард түмэндээ илүү тал засдаг жамтай. Үүнийг зарим хүмүүс “популизм” гэж буруушаах бол зарим нь ардчилал гэж хэлнэ.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ оруулагчид бол мэдээж асуудлыг тэс өөр өнцгөөс харна. Хөрөнгө оруулалтын тухай хууль яг ямар үр дүн авчрахыг тааж мэдэхэд хэцүү ч хөрөнгө оруулагчдад муугаар нөлөөлөх нь ойлгомжтой юм.

Дээр нь Н. Энхбаярыг баривчилсан явдал нь гадаадынхны сонирхолыг татаад амжжээ. *Wall Street Journal* энэ тухай бичиж, “Энхбаярыг баривчилсан нь Монголд хуульт ёс хэрэгжиж байгаа эсэхэд эргэлзэл төрүүлж байна” гэж Америкийн элчин асан *Mark Minton* хэлжээ.

Гадаадынхан асуудлыг ингэж харах нь ойлгомжтой юм. Н. Энхбаярыг баривчлах нь зөв ч байсан, буруу ч байсан гадныханд сэжиг төрүүлнэ. Монголын ардчилсан засаглал тэдний “улс төрийн эрсдэл”-ийг бууруулж байсан бол одоо энэ эрсдэлд тэд илүү санаа зовж эхэлнэ. Мэдээж хөрөнгө оруулагчид анхнаасаа улс төрийн эрсдэл байгаа гэдгийг мэдсээр Монголд хөрөнгө оруулсан. Манай МИСС шиг хөрөнгө оруулалтын банкууд хүртэл улс төрийн эрсдэлийн тухай анхааруулдаг.

Харин үүнээс болж хөрөнгө оруулагчид Монголоос үргээд явах болов уу? Асуултын хариулт нь мэдээж Монголын төр хэр хатуу хөдлөхөөс шалтгаална. Ямар ч хууль батлагдаагүй байхад энэ асуултад хариулах боломжгүй юм. Гэхдээ улс төрийн сөрөг мэдээ гарах нь зарим хөрөнгө оруулагчдын хувьд Монголыг дэндүү эрсдэлтэй мэт харагдуулж, тэдний хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх магадлалтай байдаг. Зах зээлд хөрөнгө оруулагчдын сэтгэл зүй маш чухал.

Гэхдээ гадны хөрөнгө оруулалтыг дэмжих хүмүүсээс гадна зарим хүмүүсийн хувьд гадныхан Монголоос үргээд явах нь бидний алдагдал биш амжилт юм. Тиймээс ч Монголчууд бидэнд хэлэлцэх, шийдвэрлэх асуудлууд олон байна. Монгол улс хөгжихийн тулд эрдэс баялагийн ямар бодлогыг баримтлах ёстой вэ? Эдийн засгийн өсөлт, үндэсний аюулгүй байдал хоёрын тэнцвэрийг яаж олох вэ? Гэхдээ зөвхөн эдийн засгийн өсөлт бидэнд хангалттай юу? Өөрөөр хэлбэл баялагийн хувиарлалт, байгаль орчны асуудлуудыг яаж шийдвэрлэх вэ? Энэ жилийн сонгуулийг бид эдгээр асуудлуудын тухай том яриа өрнүүлэх боломж мэтээр харвал сайн болов уу. Олны шийдвэр мэргэн байдаг.

ТЭМДЭГЛЭЛ бол улс төрийн сонин биш учраас асуудлын нэг талыг хамгаалахаасаа илүү хөндлөнгийн зүгээс бичихийг эрмэлздэг билээ. Бидний хувьд асуудлыг олон талаас нь харж, хэлэлцээрт хувь нэмрээ оруулах нь чухал юм. 🌐

САНХҮҮГИЙН БУЛАН


Бондын хөрөнгө оруулалт

Д. Дотно

ХУВЬЦААНЫ ИНДЕКСҮҮД түүхэндээ хамгийн Өндөр хэмжээндээ байгаа нь цаашдаа өсөх боломжтой эсэхэд эргэлзээ үүсгэдэг. Ийм үед бонд худалдаж авах бол өөрийн оролцоо хамгийн багатайгаар урт хугацаагаар хөрөнгө оруулж болох нэг арга зам юм.

Бондын хугацааны эцэст төлөгдөх үндсэн хэмжээг 100 нэгжээр тооцдог бөгөөд арилжааны хүүг 100-тай харьцуулснаар арилжааны үнэ бодогддог. Арилжааны хүү ихэслээ гэдэг нь хугацааны эцэст 100 нэгжийг

1800 ОНООС ХОЙШ ЖИЛ БҮРИЙН БОНДОО ТӨЛӨХ ЧАДВАРГҮЙ БОЛСОН УЛСЫН ТОО



авахын тулд өнөөдрийн төлж байгаа үнэ багассаны шинж. Еврогийн бүсийн өрийн хямрал сүүлийн 2 жилийн турш шуугиан тарьсан тул өндөр хүүтэй байх нь ямар утгатай болохыг уншигч та андахгүй байх.

Харин бондыг авсан цагаас хугацаа нь дуустал хадгална гэвэл энэ хоорондох хүүгийн өөрчлөлт таны хөрөнгө оруулалтад хамаагүй болно. Учир нь арилжааны цагаас хугацааны эцэс хүртэл хүү болон үндсэн хэмжээ өөрчлөгдөхгүй, бондын бүтэцэд заалттай байх юм. Хэдийгээр хүү унасан цагт бондоо зарж, илүү өндөр өгөөжтэй арилжаа хийж болох боловч ингэж олсон бэлэн мөнгийг хэрхэн дахиж ижилхэн өндөр хүүтэйгээр хөрөнгө оруулах вэ гэдэг төвөгтэй асуудал тулгарна. Нэг бол эрсдэл ихтэй хувьцааны зах зээлд өндөр өгөөжтэйгээр, эсвэл эрсдэл багатай ч хүү багатай хадгаламжийн өөр бонд-д оруулах хэрэгтэй болно.

Тийм ч учраас ихэнхи хувь хүмүүс бонд авахдаа хугацааг дуустал хадгалахаар төлөвлөдөг. Жишээлбэл 10 жилийн дараа та хүүхдийнхээ их сургуулийн төлбөрийг төлөх хэрэгтэй болохоо мэдэж байгаа бол одоо төлбөрийнх нь 70-80%-ийн үнээр 10-жилийн бонд худалдаж авч болох юм. Мэдээж энэ хооронд үнийн өсөлт яаж өөрчлөгдөхийг хэн ч мэдэхгүй тул ихэнхи бондын хүү нь инфляцаас өндөр байдаг. Өөрөөр хэлбэл инфляци ихтэй Монголын бонд эрхбиш инфляцигүй шахам хөгжсөн орнуудын бондоос өндөр хүүтэй байна. Гэхдээ инфляциас хамгаалалттай бонд хүртэл байдаг. Эдгээр нь одоохондоо Монгол улсад гараагүй байгаа ч Англи, Америк тэргүүтэй орнуудын төрөөс жил бүр

инфляцийн үзүүлэлтэн дээр амласан хүүг нэмж төлдөг бонд гаргадаг.

Бондын эрсдэл нь дээр хэлсэлчилэн голдуу хүүгийн хэлбэлзлийн эрсдэл мөн ч илүү эрсдлийг хүссэн хүмүүст зориулсан зах зээлийг дагаж хэлбэлзэх хүүтэй тусгай бонд ч байдаг. Мэдээж гадаадын бонд худалдаж авбал валютын ханшийн эрсдэл үүснэ. Гэхдээ үүнээс гадна таны мөнгийг зээлсэн байгууллага (төрийн ч, хувийн ч байгууллага байж болно) дампуураад өрөө буцааж төлөхгүй байх магадлал байна. Ийм тохиолдолд компанийн бонд нь хувьцаагаасаа эрсдэл багатай байдаг. Учир нь ихэнхи улсын дампуурлын хуулийн заалтаар

өрийн эзэн хувьцаа эзэмшигчидээс өмнө мөнгөө эргүүлж авах эрхтэй байдаг. Харин төр дампуурах эрсдэл харьцангуй бага ч сүүлийн 200 жилийн турш нилээд хэдэн жилүүдэд бондыг буцаан төлөхгүй байх явдал болж байсныг графикаар үзүүлээ.

Бондын хугацаа, хүү, буцаан төлөлт нь жирийн зээлийн адил төрөл бүр байдаг. Жишээлбэл хугацаанаас өмнө үндсэн хэмжээг буцааж төлж болох, хүүг бэлэн мөнгөөр бус үнэт цаасаар төлөх, хугацаа дуустал хүү төлөхгүй гэх зэрэг олон төрлийн бондууд өөр өөр эрсдэлтэй байдаг. Дараахи хүснэгтэд Монголын болон өндөр үнэлгээтэй гадаад бондуудыг жагсаалаа.

Бонд гаргагч, хүү болон хугацаа	Хүү төлөлт	Үндсэн Хэмжээ Төлөлт	Үнэ	хүү	Moody's үнэлгээ
Монгол Бонд					
МХБ 5.75% 2017	жилд 2	Хугацаанд	100.236	5.62	B1
МХБ 6% 2012	жилд 2	Хугацаанд	101.375	3.35	B1
МЗГ 8% 2018	жилд 1	Хугацаанд		~12	B1
МЗГ 9% 2018	жилд 1	Хугацаанд		~12	B1
МЗГ 0% 2007*	-	Хугацаанд	-	-	B1
Голомт Банк 0% 2017	жилд 2	Хугацаанд		-	BA3/-
ХХБ 12.5% 2015	жилд 2	Хугацаанд	101.188	11.74	B1/-
ММС 8.875% 2017	жилд 2	Эрт төлөх эрх	100.625	8.71	B1
Гадаад Бонд					
Герман 3% 2022	жилд 1	Хугацаанд	101.272	2.82	AAA
Евро СТС 2.625% 2019	жилд 1	Хугацаанд	101.194	2.41	AAA
Их Британ 4% 2022	жилд 2	Хугацаанд	117.74	2.00	AAA
Франц 3% 2022	жилд 1	Хугацаанд	101.843	2.78	AAA
Голланд 2.25% 2022	жилд 1	Хугацаанд	100.943	2.14	
J&J 4.75% 2019	жилд 1	Эрт төлөх эрх	101.843	2.78	AAA
CW Bank Aust. 3% 2022	жилд 1	Хугацаанд	101.272	2.82	AAA
Seariver M. Fin. 0% 2012	-	Эрт төлөх эрх	99625	2.47	AAA

*Хугацаа дууссан богино хугацааг бонд. Үнэ, хүү гарсан өдрөөр бичигдэв.

ТАНЫ СОНИРХОЛД

Компанийг үнэлэх нь

Б. Ачболд, Д. Дотно

БИД ӨМНӨХ дугаартаа Төгс Зах Зээлийн Таамаглалын тухай бичсэн билээ. Энэ онолыг хөрөнгө оруулагчийн зүгээс харвал компаниудыг зөв үнэлснээр ашиг олох боломжтой юм. Компанийн зөв үнэлгээг олж, тэр нь зах зээлийн үнэлгээнээс илүү байвал хувьцааны үнэ нь яваандаа зөв үнэдээ дөхөж очино гэж хөрөнгө оруулагч найдаж тухайн хувьцааг худалдаж авах юм. Ингэж найдах нь урт удаан хугацаанд зах зээл төгс болдог гэж үзэхтэй адил тул ТЗЗТ-ын хамгийн сул хэлбэртэй нийцдэг. Энэ үзлийг баримталж хямд үнэлэгдсэн хувьцааг хайхыг үнэ цэнийн хөрөнгө оруулалт буюу “*value investing*” гэж хэлдэг.

Ямар үнэлгээ зөв болох тухай хэд хэдэн үзэл байдаг. Аливаа юмны зөв үнэ бол зах зээлд борлуулагдах үнэ мөн гэж үзэж болно. Энэ үнэн бол ижил төстэй компаниудын дундаж үнэлгээ зөв байж таарна. Аливаа компанийн хувьцааны үнийг нормалчилж, зах зээлийн дундаж хувьцаанаас өөр үнэлэгдсэн эсэхийг харах юм. Ийм харьцуулалт хийхийн хамгийн чухал ажил бол хоорондоо ижилхэн орлого эрсдлийн эх үүсвэртэй, адил үйл ажиллагаатай олон компаниудыг олох хэрэгтэй. Статистикийн зүгээс бодвол олон компани байх тусмаа дундаж нь утга төгөлдөр гарах боловч зах зээл дээр тэр болгон тийм олон адилхан компаниуд байдаггүй.

Олон хувьцааг хооронд нь харьцуулахад хамгийн чухал асуудал бол зах зээлийн нийт төгс бус байдлын асар их нөлөө юм. Үнийн хөөрөгдлийн үед салбар байтугай бүхэл бүтэн эдийн засаг хамрагддаг. Богино хугацаанд үнэ хөөрөгдөх юм уу, хэт унавал зах зээлийн дундаж үнэлгээг зөв гэж гүрийхэд хэцүү. Ийм учраас хувьцааг зөвхөн бусадтай харьцуулах логикоор үнэлбэл үнийн хөөрөгдлийн сөрөг үр дагаварт өртөгдөнө. Ийм учраас л “зах зээлийн нөлөөгүйгээр хэрхэн хувьцааг үнэлэж болох бэ?” гэдэг асуудал тулгардаг.

Ирээдүйд өгөх ашгийг өнөөдрийн мөнгөөр тооцолвол зөв үнэ гарна гэсэн санаа дээрхи асуултанд хариулах бөгөөд зөв үнэ гэж юу болохыг өөрөөр тайлбарладаг. Энэ санаа нь суурь шинжилгээ ашиглах үндэслэл мөн бөгөөд ихэнхи хувьцааны судалгааг ийм аргачлалаар хийдэг. Хувьцаа авна гэдэг нь нэг компанийн өмчийг эзэмшдэг болно гэсэн үг. Энэ компани нь үйл ажиллагааныхаа ашгаас зээлийн өрөө төлчихөөд үлдсэн мөнгийг өмч эзэмшигчдэд өгч болно. Харин өмч эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр бэлэн мөнгө өгөх үү, эсвэл оронд нь илүү үр ашигтай ажиллахын төлөө хөрөнгө оруулалт хийх үү гэдгийг компанийн захирал шийднэ. Компанийг үнэлэхдээ

ирээдүйд өмч эзэмшигчдэд буцааж өгөх мөнгөний хэмжээг тооцож болно.


Гэхдээ ирээдүйн ашгийг хэн ч мэдэхгүй учир энэ мөнгийг маш олон таамаган дээр үндэслэхээс өөр аргагүй. Ирээдүйн борлуулалтын орлого, ашгийн маржин, хөрөнгө оруулалт, зах зээлээс санхүүжилт татахад төлөх хүү гэх мэт хэмжигдэхүүнийг хэдийгээр таамаглах шаардлагатай ч логиктой сэтгэснээр алдаатай үнэлгээнээс зайлсхийж болно.

Олон компаниуд ирээдүйд ашиг нь ямар хурдтай өсөх тухай таамаг гаргаж хөрөнгө оруулагчдад үзүүлдэг. Харамсалтай нь энэ өсөлт нь юуны үр дүнд үүсэхийг тэр болгон тодорхой хариулдаггүй. Компани нэг бол илүү борлуулалт хийх хүчин чадалтай болж зах зээлийнхээ илүү хэсгийг эзэлнэ, эсвэл илүү үр ашигтай ажилладаг болж өртгөө хасч ашгаа нэмэгдүүлнэ. Өөр зам байхгүй. Гэхдээ хүчин чадал нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх, үр ашгаа сайжруулахад эрхиш хөрөнгө оруулалт шаардлагатай. Бүр тодруулбал заавал *үр ашигтай* хөрөнгө оруулалт шаардана. Хөрөнгө оруулалтын *өгөөж* (ROI) гэдэг хэмжигдэхүүн нь ашгийн өсөлтийг хөрөнгө оруулалттай харьцуулж үр ашгийг хэмждэг тул энэ тоог хөрөнгө оруулагч сайтар анзаарах хэрэгтэй бөгөөд ямар хэмжээнд байх нь энэ салбарын хувьд бодитой болохыг олж мэдэх хэрэгтэй. Сайн өгөөжтэй хөрөнгө оруулалт хийж чадна гэсэн захирал нь үнэхээр хэлсэн амандаа хүрч чадах эсэхийг хөрөнгө оруулагч таамаглах ёстой.

Түүнчлэн хэдэн жилийн турш нийт эдийн засгаас илүү хурдтай өснө гэж амлаж байгааг анхаарах хэрэгтэй. Бодит амьдрал дээр шинэлэг, өсөлттэй компаниудын ашиг 2-3 жилийн турш, үсрээд 10 жилийн турш нийт зах зээлээс илүү хурдтай өсч чаддаг. Ийм учраас зохих хэмжээний жилүүдийн дараа ашгийн өсөлт нийт эдийн засгийнхтай тэнцүү болно гэж тооцох хэрэгтэй.

Мөн компанийн суурь үйл ажиллагааг үнэлэхэд санхүүжилтын үнийг таамаглана. Энэ тоог ихэнхидээ үнэ хорогдуулах хүүгийн хэлбэртэй илэрхийлдэг. Компани хувьцааны болон зээлийн санхүүжилт авахад ямар хүү төлөхийг энэ тоо тодорхойлох юм. Эдийн засаг нь тогтворгүй, эрсдэлтэй улсад санхүүжилт олоход хэцүү байдаг тул харьцангуй өндөр хүүгийн төвшинөөр ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээг хорогдуулна.

Ийм үнэлгээ хийх нь нэг ёсондоо хөрөнгө оруулагч бүр өөрийн тооцооллоор хувьцааны үнийг хэд байх нь зөв болохыг тооцоолбол аяндаа арилжааны үнэ энэ тоотой улам ойртоно гэж үзэж байна гэсэн үг. Ингэснээр зах зээлд хямд үнэлэгдэж байсан хувьцаа хэсэг хугацааны дараа зөв үнэлгээндээ ойртоно гэж хөрөнгө оруулагч найдах юм. Энэ нь ТЗЗТ-ын сул хэлбэрийг зөв гэж үзэж байгаатай адил. ☼



MICC

Mongolia's Investment Bank

THIS IS THE MICC JOURNAL, A BI-MONTHLY FINANCE AND ECONOMICS PAPER PUBLISHED BY MICC, THE LEADING INVESTMENT BANK IN MONGOLIA.

МIСС хөрөнгө оруулалтын банкны тухай
МIСС нь компанийн санхүүжилт, үнэт цаасны арилжаа,
судалгаа, хөрөнгийн удирдлага зэрэг цогц үйлчилгээг
дотоод гадаадын харилцагчиддаа санал болгодог
Монголын ууган хөрөнгө оруулалтын банк юм.

МIСС ТЭМДЭГЛЭЛ – ийн тухай
Хоёр долоо хоног болгон гарах энэ бяцхан сонин
танд эдийн засаг, санхүүгийн мэдээлэл өгөх
боловч хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөхгүй.

Таны эрсдэл таны хариуцлага.

Эрхлэгч: Б. Ачболд.

2012/5/10

Мэдээллийн эх сурвалж:
Bloomberg, Монголын
Хөрөнгийн Бирж.